

СҮХБААТАР АЙМГИЙН ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Ж.Ганбаатар¹, Х.Жамъянсүрэн²

¹Судлаач, бэлтгэл хурандаа

²ДХИС-ийн Ахисан шатны боловсролын сургуулийн магистрант,
ахмад

Цахим шуудан: x.jamia1024@gmail.com

Хураангуй

Улсын хэмжээнд 2020 онд ой, хээрийн гал түймэр Улаанбаатар хот, Архангай, Булган, Говьсүмбэр, Завхан, Дорнод, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Төв, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Увс зэрэг 15 аймгийн 74 суманд нийт 142 удаагийн ой, хээрийн түймэр гарч, урьдчилсан байдлаар 9549.3 га ой, 235.762 га хээр, нийт 245.311 га талбай, 2 гэр, 4 айлын өвөлжөө, 2 автомашин түймэрт өртөж, экологийн хохирол 3 тэрбум, эд материал 41.1 сая, түймрийг унтраахад 145.4 сая төгрөг зарцуулж, нийт 3.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна

Сүхбаатар аймагт сүүлийн арван жилийн гамшиг осол, аюулт үзэгдлийн судалгааг авч үзэхэд нийт 763 удаагийн дуудлага ирсэн үүний 34.9 хувь хээрийн түймэр эзэлж байна. Байгалын болон хүний үйл ажиллагааны эх үүсвэртэй гал түймэрт экологи ихээхэн өртөж, багагүй хохирлыг эдийн засагт учруулдаг. Энэхүү өгүүллэгээр Сүхбаатар аймгийн хээрийн түймрийн өнөөгийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэж буй арга хэмжээ, цаашид авах арга хэмжээний талаар дурьдсан болно.

Түлхүүр үгс: Хээрийн түймэр, хохирол, хамтын ажиллагаа

Удиртгал

Сүхбаатар аймаг нь далайн түвшинээс дээш 994 м өргөгдсөн бөгөөд хамгийн өндөр цэг нь Шилийн богд 1778 м, хамгийн нам дор газар нь Монгол Дорнод талын их мужийн Дорнод хотгор, Баруун-Урт хотыг дайран зүүн хойноосоо баруун ургаш сунаж тогтсон далайн түвшингээс дээш 994 м, орчим өргөгдсөн, нийт нутгийн 78.3 хувь нь тал хээрийн бүсэд үлдэх 21.7 хувь нь говийн бүсэд оршино.

Салхины дундаж хурд 2,8-5,9 м/с үнэмлэхүй их хурд нь 20-40 м/с байна. Жилийн дундаж температур нь 0,4-2,4 хэм, хамгийн хүйтэн үе нь -39-43 хэм, хамгийн халуун үе нь 39-42 хэмд хүрнэ.

Жил бүр улсын хэмжээнд гарч байгаа гал түймрийн шалтгаан нөхцлийг нутаг дэвсгэрийн онцлог байдал, байгаль экологи, цаг агаарын нөхцөл, гал гарч байгаа зонхилох шалтгаанаар үнэлгээ дүгнэлт өгч, гал

түймрийн шалтгаан нөхцлийг улирал, сар, өдөр, цаг, гарагаар судлахад дараах үзүүлэлт гарсан юм.

Ой хээрийн түймрийг гаралтын давтамжийг сараар тодорхойлбол 8,9,4,5 дугаар саруудад нийт гал түймрийн 55-70 хувь гардаг нь хавар, намрын хуурайшилттай улирал эхэлж салхины хүч ихсэх, түүнчлэн сүүлийн жилүүдэд дэлхийн цаг агаарын уур амьсгалын эрс өөрчлөлтөөс шалтгаалан зуны улиралд хэт халалт үүсэн байгаагаас шалтгаалн гардагтай холбож үзэх үндэслэлтэй юм. Түүнчлэн түймрийн 65.5 хувь нь 12-16 цагийн хооронд гарч байна.

Ой хээрийн түймрийн тоог 7 хоногийн гаригууд болон цагаар харьцуулсан үзүүлэлтээс дүгнэлт хийхэд Даваа, Пүрэв /нийт галын 31 хувь/ хамгийн бага гарсан Лхагва гараг /12 хувь/, цагийн байдлаар 06-12, 16-18 цагуудад нийт гал түймрийн 33.5 хувь нь гарсан байна. /түймрийн нөхцөл байдалд хийсэн судалгаанаас/

Сүхбаатар аймгийн хээрийн түймрийн өнөөгийн нөхцөл байдал

2014 онд аймгийн 5 суманд 67 удаа гал түймэр гарснаас 1.3 сая/га хээр өртөж байгаль, эколгид 111433304 төг, эд материалд 478208600 төг, нийт 661859364 төгрөгийн хохирол учирж, түймрийн улмаас 1 хүн нас барж, 4 хүн түлэгдэж бэртсэн байна.

2015 онд аймгийн 6 суманд 47 удаа гал түймэр гарснаас 19.6 сая/га хээр өртөж байгаль, эколгид 3.7 /тэрбум/ төг, эд материалд 4.06 /тэрбум/төг, нийт 7.9 /тэрбум/төгрөгийн хохирол учирж, түймрийн улмаас 9 хүн түлэгдэж бэртсэн байна.

2016 онд аймгийн 6 суманд 34 удаа гал түймэр гарснаас 491685 га хээр өртөж байгаль, эколгид 1.8 /тэрбум/ төг, эд материалд 1.08 /тэрбум/ төг, нийт 3.01 /тэрбум/ төгрөгийн хохирол учирж, түймрийн улмаас 4 хүн нас барсан байна.


2017 онд аймгийн 5 суманд 35 удаа гал түймэр гарснаас 69697 га хээр өртөж байгаль, эколгид 389035128 төг, эд материалд 71320000 төг, нийт 475563737 төгрөгийн хохирол:

2018 онд аймгийн 5 суманд 12 удаа гал түймэр гарснаас 19470 га хээр өртөж байгаль, эколгид 378169006 төг, эд материалд 155732050 төг, нийт 543654586 төгрөгийн хохирол:


2019 онд аймгийн 5 суманд 10 удаа гал түймэр гарснаас 5530 га хээр өртөж байгаль, эколгид 48672522 төг, нийт 51115172 төгрөгийн хохирол:

2020 онд аймгийн 4 суманд 7 удаа гал түймэр гарснаас 15758 га хээр өртөж байгаль, эколгид 224404560 төг, нийт 225805760 төгрөгийн хохирол:

**Сүхбаатар аймагт гарсан хээрийн гал
Түймэр 10 жилийн судалгаа /сумдаар/**



Сүүлийн 10 жилийн хээрийн түймэр, ажилсан хүн хүчний судалгаа



СҮХБААТАР АЙМГИЙН 2011-2020 ОНД ГАРСАН ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН СУДАЛГАА

№	Түймэр гарсан он	Түймрийн тоо	Учирсан хохирол /сая төг/						Ажилласан хүн, хүч		
			Хээр /га/	Экологийн	Эд материалын	нас барсан	түлэгдэж гэмтсэн	нийт зардал	ОБГ	Орон нутаг	Машин техник
									Хүн	хүн	
1	2011	6	207560	24100000	66900000	-	-	95500000	95	516	48
2	2012	22	78842	5582428	612000	-	-	2479076	265	998	127
3	2013	25	510409	20230541	-	-	-	37796796	226	1111	247
4	2014	67	1218308	111433304	478208600	1	4	661859364	879	2677	438
5	2015	47	1960365	3782486286	4056524096	-	9	7970361901	728	2942	610
6	2016	34	491685	1892638619	1087566309	4	-	3012131233	420	710	181
7	2017	35	69697	389035128	71320000	-	-	475563737	235	305	62
8	2018	14	19470	378169006	155732050	-	-	543654586	203	294	61
9	2019	10	5530	48672522	-	-	-	51115172	96	92	22
10	2020	7	15758	224404560	-	-	-	225805760	73	166	34
нийт		267	4577624	6879752394	5916863055	5	13	13076263265	3220	9811	1830

Сүхбаатар аймгийн хээрийн түймрийн сүүлийн 10 жилийн судалгаанаас харахад аймгийн 12 суманд 267 удаа хээрийн түймэр гарснаас 4.6 сая/га хээр өртөж байгаль, эколгид 6.9 /тэрбум/ төг, эд материалд 5.9 /тэрбум/ төг, нийт 13 /тэрбум/ төгрөгийн хохирол учирж, түймрийн улмаас 5 хүн нас барж, 13 хүн түлэгдэж бэртэж, унтраах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагаас 320 автомашин, 3241 алба хаагч, Хил хамгаалах байгууллагаас 83 машин техник, 586, Цагдаагийн байгууллагаас 13 машин техник 156, зэвсэгт хүчний анги нэгтгэлээс 14 машин техник 217, Орон нутгийн мэргэжлийн анги, ААНБ, ард иргэдийн 1564 машин техник, 9917 иргэдийг татан оролцуулсан байна.

Дээрх түймрээс жишээ татвал 2016 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын 5 дугаар багийн нутаг “Баянцагаан” гэдэг газарт хээрийн түймэр гарч 271426 га хээр өртөж байгаль, эколгид 1036033042 төгрөг, 14 гэр, 2826 толгой мал өртөж, эд материалд 849455000 төг, нийт 1891764046 /нэг тэрбум найман зуун ерөн нэг сая долоон зуун дөчин мянга дөчин зургаан/ төгрөгийн хохирол учирж, түймрийн улмаас 4 хүний эрдэнэт амь хохирч, унтраах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагаас 4 техник, 48 алба хаагч, Орон нутгаас 52 техник 210 иргэн, Цагдаагийн байгууллагаас 2 техник 7 алба хаагч ажиллаж унтраасан байна.

Хээрийн түймэртэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

Хууль эрх зүйн шинэчлэлттэй холбоотой түймэртэй тэмцэх талаар хууль эрх зүйн хүрээнд Ойн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулиудыг шинэчилэн найруулж батлуулсан. Мөн түүнчлэн ой хээрийн түймэртэй тэмцэх зорилгоор дараах гэрээ, хэлэлцээр, уулзалтыг зохион байгуулсан байна

Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар, БНХАУ-ын Иргэний хэргийн яамтай 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотод зохион байгууллагдсан уулзалтаар хоёр талаас 5 жилийн хугацаатай “Харилцан ойлголцолын санамж бичигт” гарын үсэг зурсан.

Аймгийн Онцгой байдлын хэлтэс БНХАУ-н ӨМӨЗО-ны Хөлөнбуйр аймгийн Зүүн барга хошууны Хайлаар хотын Ой шугуйны галаас сэргийлэх албатай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр зэрэг ажлуудыг аймгийн орон нутгийн хэмжээнд зохион байгуулж ажиллаж байна.

ӨМӨЗО-ны зүүн үзэмчин хошуутай хиллэдэг Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумдын удирдлага, Цэргийн хэлтэс, Хилийн 0146 дугаар анги, Онцгой байдлын газрын холбогдох албан тушаалтан оролцсон албан ёсны

хилийн уулзалтыг 2 жилд 1 удаа зохион байгуулж гамшгийн талаарх мэдээ, мэдээллийг харилцан солилцох, ой хээрийн түймрийг хил давуулахгүй байх, түймэр гарсан тохиолдолд хилийн бүс болон хил даваж түймэр унтраах бүлгийг хялбаршуулсан байдлаар хил нэвтрүүлэх тухай гэрээг байгуулсан байна.

2014-2016 оны хооронд Монгол Улс, Хятад улсын хилийн бүс орчмын ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хурал. Мөн 2016 онд Монгол Улсын Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймаг болон Хятад улсын ӨМӨЗО-ны хилийн бүс орчмын ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх бага хурлын дагуу Монгол Улс, Хятад улсын хилийн бүс орчмын ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамтран ажиллах гэрээг нэг шат ахиулахад Хятад талаас 100 хувийн санхүүжилтээр Эрдэнэцагаан сум дахь Гал түймэр унтраах, аврах 47 дугаар ангийн барилгын депог 1.2 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламжаар бариулж 2019 оны 09 дүгээр сард ашиглалтанд оруулсан.



Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын хэмжээнд сүүлийн 5-н жилийн хугацаанд нийт 33 удаагийн хээрийн түймэр гарч, 278686 га талбай шатаж, байгаль экологид 963,297,761 төгрөгний хохирол, түймэр унтраахад гарсан шууд зардал 38,695,270 төгрөг, ард иргэдийн өмч хөрөнгөнд 234,613,800 төгрөг, нийт 1,236,606,831 /нэг тэрбум хоёр зуун гучин зургаан сая зургаан зургаан мянга найман зуун гучин нэгэн/ төгрөгний хохирол тус тус учирсан байна.

Түймрийн улмаас 6-н айлын гэр, 1 автомашин, техник 77 толгой мал, 29100 бэлдэж боосон өвс, 5 өрхийн малын хашаа саравч, 73 айл өрхийн 2000 орчим хилийн өргөст утсан хашааны шон тус тус шатсан байна.

Түймэр унтраах ажиллагаанд Онцгой байдлын албанаас давхрадсан тоогоор 341 албан хаагч, 29 автомашин, Хилийн цэрэг, Цагдаагийн



байгууллагаас 142 албан хаагч, 12 автомашин орон нутгаас 487 иргэн 41 автомашин нийт 970 хүн, 82 авто машин, техник дайчилагдан ажиллаж унтраасан байна.

Сүхбаатар аймгийн эрдэнэцагаан суманд Гал түймэр унтраах, аврах анги 2016 онд байгуулагдсанаар хээрийн түймрийн тоо хохирол буурч бодит үр дүнд хүрч, хил дамнасан түймрийн зөрчил дутагдал сүүлийн 3 жилд Сүхбаатар аймагт гараагүй байна.

Зүүнбүсийн аймгуудын Онцгой байдлын газрууд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрэн хайх, аврах хор уршгийг арилгах чиглэлээр хамтран ажиллах гэрээ, хамтран ажиллах төлөвлөгөөг боловсруулж, Зүүн бүсийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж ажилладаг боловч бодит байдал дээр төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хөрөнгө мөнгийг тодорхой тусгах, алба хаагчдын ур чадварыг сайжруулах бүсийн хэмжээний дадлага сургуулилт хийх шаардлагатай байна.

Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2015 оны 04, 126 дугаар тушаалаар батлагдсан “Хамтран ажиллах төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах, хилийн зурвас, бүсэд хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Сүхбаатар аймгийн Онцгой байдлын газар, Хилийн 0146, 0184 дүгээр ангиудын захирагч нар жил бүр харилцан ажиллах төлөвлөгөөг баталгаажуулж, хил орчмын нутаг дэвсгэрт

гарсан хээрийн түймрийг шуурхай унтраах, хил давахаас урьдчилан сэргийлэх, хил залгаа улсын талд хилийн төлөөлөгчийн шугамаар мэдэгдэж шуурхай арга хэмжээг авах, шаардлагатай тохиолдолд Онцгой байдлын алба хаагч, БНХАУ-ын холбогдох алба, иргэдийг хялбаршуулсан журмаар хил нэвтрүүлэх, түймрийн хор уршгийг арилгах нөхцлийг бүрдүүлж, унтраах ажилд дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

Дүгнэлт

Хээрийн гал түймрийг унтраахад маш чухал зүйл бол удирдлага зохион байгуулалт, удирдагчийн шийдвэр юм. Гал түймэр унтраах удирдагч нь шийдвэрийг гаргахдаа хамгийн түрүүнд цагийн байдлыг зөв үнэлэх ёстой бөгөөд цагийн байдлыг үнэлэхэд мэдээллийг хурдан шуурхай цуглуулах ёстой байдаг.

Хээрийн түймэр дээр ажиллаж байгаа бүлгүүдийн харилцаа холбоо дамжуулах техник хэрэгсэл дутмагаас хээрийн түймэр унтраах үеийн удирдлага зохион байгуулалт алдагдах зэрэг хүндрэл гарч байна.

Хээрийн түймрийн өнөөгийн нөхцөл байдал нь жил бүр харилцан адилгүй байгаа ч улс орны эдийн засаг, байгаль экологид ихээхэн хохирол учруулсаар байна. Хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга замууд олон байдаг ч тэдгээр арга замуудаас иргэдийг сургаж дадлагажуулах асуудал тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Санал:

1. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, нийслэл, сум, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна гэж заасанг бүх түвшинд хэрэгжүүлж хөрөнгийг шийдвэрлэх асуудлалд дээд түвшинд хяналт тавьж шийдвэрлүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж тогтмолжуулах шаардлагатай байна.
2. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Хил дагуух ой хээрийн түймэртэй тэмцэх газартай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, хээрийн түймэр унтраах арга зам, хээрийн дадлага сургуулийг судлан харилцан туршлага солилцож ажиллах.

Ашигласан материал:

1. МУ-ын Галын аюулгүй байдлын тухай хууль

2. МУ-ын гамшгаас хамгаалах тухай хууль
3. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөр
4. Сүхбаатар аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гамшиг ослын сүүлийн 10 жилийн судалгаа
5. 2014-2016 оны хооронд Монгол Улс, Хятад улсын хилийн бүс орчмын ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хурлын хэлэлцүүлэг